



ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/57

Биндэр сум

Мал амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Хэнтий аймгийн Засаг даргын 2026 оны А/156 дүгээр захирамж, Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2026 оны А/22 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнээр баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Х.Гэлэгжамц	Мал эмнэлгийн тасгийн дарга
Гишүүд:	Н.Болормаа	1-р багийн Засаг дарга
	Э.Мөнгөншагай	2-р багийн Засаг дарга
	Ж.Ганзоригт	3-р багийн Засаг дарга
	Х.Амарзаяа	4-багийн Засаг дарга
	Б.Тунгалаг	5-р багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Ц.Цогтбаатар Тархвар зүйч

2. Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг 2026 оны 04 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 2026 оны 10 дугаар сарын 01-ныг хүртэлх хугацаанд зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасагт үүрэг болгосугай.

3. Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээг орон нутагтаа графикт хугацаанд нь шуурхай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн Малын эмч (Н.Ган-Од, Ц.Ган-Од, Д.Алтанцэцэг, С.Шүрэнчулуун, Ш.Отгон) нарт, Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх төлөвлөгөөт ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, зохион байгуулах, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж дүнг нэгтгэж танилцуулахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Ц.Цогтбаатар)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Өнөболд)-д, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний үр дүнг дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Ц.Цогтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

